

## НИЙСЛЭЛИЙН СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗРЫН ШАГНАЛ УРАМШУУЛЛЫН ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Төрөөс соёлын талаар баримтлах бодлого, Соёлын тухай хууль, Нийслэлийн соёлын бодлого, Нийслэлийн Соёл, урлагийн газрын үйл ажиллагааны чиг үүргийг хэрэгжүүлэх соёл, урлагийн салбарыг хөгжүүлэх үйл хэрэгт үр бүтээлтэй ажиллаж, тодорхой амжилт гаргасан байгууллага, ажилтан, албан хаагч, Монгол улсын иргэн, холбогдох гадаад улсын иргэнийг Нийслэлийн Соёл, урлагийн газрын шагналаар шагнаж урамшуулахад энэхүү журмыг мөрдөнө.

### Хоёр. Шагналын төрөл

2.1 Нийслэлийн Соёл, урлагийн газрын шагнал нь дор дурдсан төрөлтэй байна.

#### 2.1.1 Хүндэт өргөмжлөл

“Хүндэт өргөмжлөл”, Мөнгөн шагнал /100 000 төгрөг /

#### 2.1.2 Нийслэлийн Соёл, урлагийн газрын “Хүндэт Тэмдэг”

- “Тэмдэг”, Мөнгөн шагнал /50 000 төгрөг/

#### 2.1.3 Өргөмжлөл

“Өргөмжлөл”, Мөнгөн шагнал /30 000 төгрөг /

### Гурав. Шагналд нэр дэвшигчдэд тавигдах шаардлага

3.1 **“Хүндэт өргөмжлөл”**-ээр Соёл, урлагийг хөгжүүлэх, түгээн дэлгэрүүлэх үйлсэд онцгой хувь нэмэр оруулсан салбартаа нэр хүндтэй хөдөлмөрөөрөө тэргүүлсэн улсад 20-оос доошгүй жил ажилласан ажилтан, албан хаагч, мөн дотоод гадаадад соёл, урлагийн салбарыг хөгжүүлэхэд онцгой хувь нэмэр оруулсан, соёл урлагийг сурталчилан олон нийтэд таниулсан албан байгууллагыг шагнана.

3.2 **“Хүндэт тэмдэг”**-ээр Соёл, урлагийн салбарт 10-аас доошгүй жил тогтвор суурьшилтай ажиллаж хөдөлмөрийн өндөр амжилт гаргасан ажилтан, албан хаагчийг шагнана.

3.3 **“Өргөмжлөл”**-өөр салбартаа 5-аас доошгүй жил ажиллаж хөдөлмөрийн амжилт үзүүлсэн ажилтан, албан хаагчийг шагнана. Соёлын биет бус өвийг өвлөн уламжилж, сурталчилан таниулж онцгой амжилт гаргасан иргэнийг шагнана.

3.4 Шагналыг зайлшгүй тохиолдолд мөнгөн урамшуулалгүй олгож болно.

3.5 Энэ журмын 2.1-д заасан шагналыг баяр ёслол, уралдаант тэмцээн, тэмдэглэлт ойн өдрийг тохиолдуулан тус тус олгоно.

3.6 Энэ журмын 2.1-д заасан шагналаар шагнахад дор дурдсан болзлыг хангасан байна. Үүнд:

#### Дөрөв. Шагналд шийдвэрлэх, олгоход тавигдах шаардлага

4.1 Шагналд нэр дэвшүүлэх хүсэлт, тодорхойлолтыг тухайн ажилтны ажилладаг байгууллага, хамт олон гаргаж, дараахь баримт бичгийг бүрдүүлсэн байна. Мөн шагналын болзлыг хангасан, соёл урлагийн салбарын байгууллагад ажиллаж байгаа албан хаагч болон тухайн байгууллагаас өндөр насны тэтгэвэрт гарсан ахмад ажилтныг үндсэн байгууллага нь тодорхойлно.

- Тухайн байгууллагын хүсэлт
- Нэр дэвшигчийн анкет, мэдүүлэг /2 дугаар хавсралтаар/
- Хамт олны хурлын тэмдэглэл
- Нэр дэвшигчийн ажил байдал, амжилтын үзүүлэлтийн тухай тодорхойлолт

4.2 Дээрх баримт бичгийг бүрдүүлж тэмдэглэлт баяр ёслолын өдрөөс 14-өөс доошгүй хоногийн өмнө Нийслэлийн Соёл, урлагийн газарт ирүүлнэ. Баримт бичиг дутуу тохиолдолд шагнал олгогдохгүй болно.

4.3 Шагналд нэр дэвшигчдийн баримт бичгийг буцаан олгохгүй, тус газрын архивийн нэгж болгон хадгална.

4.4 Шагналын баримт бичгийг хуурамчаар бүрдүүлсэн нь нотлогдсон тохиолдолд, баримт бичгийг тодорхойлсон байгууллагад буцаан өгч, тухайн албан хаагч, байгууллага, аж ахуйн нэгжид шагнал олгох асуудлыг дараагийн 3 жилд авч хэлэлцэхгүй.

#### Тав. Шагнуулах хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх, гардуулах

5.1 Шагнуулах хүсэлтийг Нийслэлийн Соёл, урлагийн газрын бичиг хэргийн ажилтан хүлээн авч, хүний нөөцийн мэргэжилтэнд шилжүүлэн, дагалдах баримт бичгийг судлан, даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, газрын дарга батламжилна. Шагнагдагсдын бүртгэлийг хөтөлнө.

5.2 Шагналуулах хүсэлтэд санал дэвшүүлж буй иргэн, байгууллага, аж ахуйн нэгжийн мэдээллийг үнэн зөв, тодорхой бичих ба тус салбарт гаргасан үр дүн, идэвхи санаачлагыг дэлгэрэнгүй бичнэ. Шагналд нэр дэвшигчийн бичиг баримтад байгууллагын дарга, захирал, эрхлэгч гарын үсэг зурж, тамга тэмдэг дарж баталгаажуулна.

5.3 Ажлын амжилт гаргасан хүмүүсийг шагнахад шагнал хоорондын зай 2-оос доошгүй жил байх бөгөөд урьд тогтоосон амжилтийг бататган ахиулсан байна.

5.4 Нийслэлийн Соёл, урлагийн газрын шагналыг доороос нь дээш өгсүүлэх зарчмыг баримтална. Гэхдээ онцгой идэвхи, зүтгэл, хүч чармайлт гаргаж амжилтад хүрсэн хүмүүсийг шагнахад дээрх зарчмыг баримтлахгүй байж болно.

5.5 Нийслэлийн Соёл, урлагийн газрын шагналаар нэхэн шагнахгүй.

5.6 Шагналыг гардуулах үйл ажиллагааг тэмдэглэлт ойн баяраар нэгдсэн зохион байгуулалтын дор газрын дарга гардуулж болно.

5.7 Шагналд шаардагдах зарлыг тухайн жилийн үйл ажиллагааны төсөвт тусган шийдвэрлэнэ.

Зургаа. Шагналын одон, тэмдэг, өргөмжлөл, үнэмлэхийг  
нөхөн болон сольж олгох

6.1 Нийслэлийн Соёл, урлагийн газрын шагналыг аливаа шалтгаанаар үрэгдүүлсэн, гэмтээсэн тохиолдолд хүсэлт гаргасаны дагуу шагналын эзэн болон түүний ар гэрийхэнд нь тухайн шагналын үнээр нөхөж эсвэл сольж олгож болно.


Долоо. Шагналын мэдээллийн сан

7.1 Тус газраас олгогдсон шагналын мэдээллийн сантай байна.

7.2 Мэдээллийн санг бүрдүүлэх, баяжуулах, түүнд нэмэлт өөрчлөлт оруулах ажлыг тус газрын шагналын асуудал хариуцсан мэргэжилтэн эрхэлнэ.

## ШАГНАЛД НЭР ДЭВШҮҮЛЭХ АЖИЛТНЫ АНКЕТ

1. Ургийн овог
2. Эцэг, эхийн нэр
3. Өөрийн нэр
4. Регистрийн дугаар
5. Нас, хүйс
6. Яс, үндэс
7. Үндсэн захиргаа



8. Боловсрол, мэргэжил эзэмшсэн байдал /он дарааллаар/:

№	Төгссөн сургууль	Суралцсан хугацаа	Эзэмшсэн боловсрол, мэргэжил
1			
2			
3			

9. Ажил эрхэлсэн байдал /он дарааллаар/

№	Ажлын газрын нэр	Ажилласан хугацаа /он сараар/	Эрхэлсэн ажил, албан тушаал
1			
2			
3			
4			

10. Соёл, урлагийн салбарт ажилласан жил: \_\_\_\_\_

11. Тус газартай хамтран ажилласан жил: \_\_\_\_\_

12. Ямар шагналд нэр дэвшүүлж байгаа /шагналын нэрийг бичнэ үү/:

13. Шагнагдаж байсан шагналууд /он дарааллаар бичих бөгөөд тус газрын өргөмжлөлөөр шагнагдаж байсан бол түүний хуулбарыг заавал хавсаргана/:

№	Шагналын нэр	Авсан хугацаа
1		
2		
3		
4		

14. Шагнагдах шалтгаан, үндэслэл /тусдаа А4 цаасаар хавсаргаж өгч болно/:

## ШАГНАЛД НЭР ДЭВШҮҮЛЭХ БАЙГУУЛЛАГЫН АНКЕТ

1. Байгууллагын нэр:

\_\_\_\_\_

2. Төрөл /тохирохыг бөглөнө үү, олон сонголттой/:

а. Төрийн б. Төрийн бус в. Боловсролын /мэргэжлийн, дээд, дунд, бага/ г. Шинжлэх ухааны д. Олон нийтийн е. Соёл, урлагийн ё. Сайн дурын ж. Худалдаа з. Үйлдвэрлэл и. Бусад \_\_\_\_\_

3. Үндсэн захиргаа: \_\_\_\_\_

4. Соёл, урлагийн салбарт ажилласан жил: \_\_\_\_\_

5. Тус газартай хамтран ажилласан жил: \_\_\_\_\_

6. Ямар шагналд нэр дэвшүүлж байгаа /шагналын нэрийг бичнэ үү/:

\_\_\_\_\_

7. Шагнагдаж байсан шагналууд /он дарааллаар бичих бөгөөд тус газрын өргөмжлөлөөр шагнагдаж байсан бол түүний хуулбарыг заавал хавсаргана/:

№	Шагналын нэр	Авсан хугацаа
1		
2		
3		
4		

Т ьрхнг

8. Шагнагдах шалтгаан, үндэслэл /тусдаа А4 цаасаар хавсаргаж өгч болно/: